

Өдөр бүр уулзах  
үндэсний шилдэг компани



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022





“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022

## АГУУЛГА

6	Мэндчилгээ
6	Төлөөлөн удирдах зөвлөл
9	2022 оны зорилго, зорилтууд
10	Түүхэн товчоо
13	2022 оны онцлох ажлууд
	<b>Хүний нөөц хөдөлмөрийн харилцааны талаар</b>
18	Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар
20	Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв
22	Шуудангийн технологийн ажлын хүрээнд
24	Мэдээллийн технологи
	<b>Тээвэр зууч, логистикийн ажлын хүрээнд</b>
25	Хот доторх хүргэлт буюу гараас-гарт хүргэлтийн үйлчилгээ

**Улс хоорондын шуудангийн хэвийн үйл  
ажиллагааг хангах**

26 Гадаад шуудангийн үйл ажиллагаа

28 Дотоод шуудангийн үйл ажиллагаа

**Санхүүгийн үйлчилгээ**

31 Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

**Марк үнэт цаасны үйлдвэрлэлийн ажлын хүрээнд**

32 Марк үйлдвэрлэл

39 Дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл

40 **Санхүүгийн ажлын хүрээнд**

48 **Аудитын тайлан**

## МЭНДЧИЛГЭЭ

### Хүндэт хувьцаа эзэмшигч танаа !

Шуудангийн үйлчилгээний өндөр хариуцлагатай үүргийг нэр төртэй гүйцэтгэхэд өөрийн мэдлэг чадвараа зориулан, ажиллаж буй нийт шууданчдынхаа 2022 оны ажлыг дүгнэн, хийж, хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн хувьцаа эзэмшигч танд хүргэж байгаадаа баяртай байна.



“Монгол шуудан” ХК-нь 2016 онд төр, хувийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн зохион байгуулагдсан бөгөөд 2017-2022 он хүртэл дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө боловсруулан Уламжлалт үйлчилгээг хөгжүүлэх, Логистик үйлчилгээг өргөжүүлэх, Санхүүгийн үйлчилгээг эхлүүлэх гэсэн 3 үндсэн чиглэлийн хүрээнд зорилго, зорилтуудаа тодорхойлон амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

Өнгөрч буй 2022 онд Монгол улс төдийгүй дэлхийн бусад улс орнуудын хувьд улс төр, нийгэм эдийн засаг, тээвэр логистик, төлбөр тооцоо, харилцаа холбооны гэх мэт бүхий л салбарт цар тахлын дараах хүндрэл, бэрхшээлүүд тулгарсан, өөрчлөлт, шинэчлэлтүүд өрнөсөн томоохон сорилтын жил байлаа. Гэсэн хэдий ч компанийн хувьд өөрчлөлт, шинэчлэлтэд дасан зохицох, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулахад чиглэсэн богино хугацааны стратеги, зорилго, зорилтуудыг боловсруулан улс хоорондын бизнесийг өргөжүүлэх, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай цахим шилжилт, программ хангамж, техник технологиудад хөрөнгө оруулалт хийж, компанийн үйл ажиллагааг шинэ төвшинд гаргахаар зорин ажиллаж байна. Улс хоорондын бизнесийг өргөжүүлэх ажлын хүрээнд гол харилцагч орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, бусад ач холбогдол бүхий улс, орнуудын шуудангийн байгууллагатай стратегийн түвшинд хамтран ажиллах боломжуудыг бий болгоход чиглэсэн уулзалт, хэлэлцээрүүдийг хийж гэрээ байгуулан ажиллаа.

Дээрх ажлуудын хүрээнд Америкийн нэгдсэн улс, Европын холбооны улсууд болон гол орнуудаас ирэх шуудангийн үнэ, тарифыг бууруулах, хугацааг богиносгох, онлайн худалдааны тээвэр логистикийн чиглэлд үйл ажиллагааг өргөжүүлэх шинэ боломжууд бүрдэж байна. Цаашид компанийн үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологиудыг нэвтрүүлэн, шуудангийн салбартаа цахим шилжилтийг нэвтрүүлж, хүргэлт, тээвэр, логистикийн салбарыг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх чиглэлд урт болон дунд хугацааны стратеги, зорилго, зорилтуудаа боловсруулан ажиллаж байна.

Энэхүү зорилгыг биелүүлэхэд хичээл зүтгэлээ зориулан ажилладаг нийт шууданчид болон бидэнд итгэл хүлээлгэн хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигч танд халуун талархал илэрхийлье.

Та бидний зорилго нэг байж, ажил үйл өөдрөг байхын ерөөлийг өргөж 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж байгааг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн:  
Гүйцэтгэх захирал **Б. АНХБААТАР**

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Даваахүү  
**НАРАНГЭРЭЛ**

ТУЗ-ийн дарга  
ТӨБЭГ, Төрийн өмчийн  
бүртгэл хяналтын  
хэлстийн дарга



Даваасамба  
**ДЭЛГЭРМАА**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин  
урамшууллын хорооны дарга  
ТӨБЭГ, Хууль зүйн албаны дарга



Гэрэлт  
**ТЭЛМЭН**

ТУЗ-ийн гишүүн



Дашбалдан  
**ЖАВХЛАН**

ТУЗ-ийн гишүүн  
“Цахим хөгжил, харилцаа  
холбооны яам,  
Хяналт шинжилгээ, үнэлгээ,  
дотоод аудитын газрын дарга”



Одончимэд  
**ОДБАЯР**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
Стратеги, эрсдэлийн  
удирдлагын хорооны дарга  
“Шивээ овоо” ХК-ийн  
ТУЗ-ийн дарга



Дарамбазар  
**БАЛДОРЖ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Аудитын хорооны дарга  
Маркетингийн холбоо,  
Удирдах зөвлөлийн гишүүн



Ванчиг  
**ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
BSP компанийн удирдах  
зөвлөлийн дарга



Даваадорж  
**БАЛЖИННЯМ**

ТУЗ-ийн гишүүн  
ЗГХЭГ, Захиргаа, хүний  
нөөцийн удирдлагын газрын  
дарга



Банзрагч  
**ГАНБААТАР**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Монголын өмгөөлөгчдийн  
холбоо, Өмгөөлөгч



Өдөр бүр уулзах үндэсний  
шилдэг компани



КОВИДЫН ҮЕИЙН ШУУДАНГИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН  
ӨСӨЛТИЙГ ХАДГАЛАХ

---

ГАДААД ШУУДАНГИЙН ОРОХ УРСГАЛЫГ  
СЭРГЭЭЖ, ГАРАХ УРСГАЛЫН ӨСӨЛТИЙГ  
ХАДГАЛАХ

---

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЖ,  
ШУУДАНГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЦАХИМААР ҮЗҮҮЛДЭГ БОЛОХ

---

ҮР ДҮНД СУУРИЛСАН ЦАЛИН  
УРАМШУУЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ,  
БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

# МОНГОЛ ШУУДАНГИЙН ТҮҮХ

1921-2022 он



Шуудан харилцаа нь Хүннү гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгөдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам “Монголын Морин Өртөө”-нөөс үүсэлтэй.

Монголын морин өртөө шуудан нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч тэргүүн зэргийн харилцаа холбооны нэгэн төрөлд тооцогддог билээ.



Шуудан хуваарилах тасаг.  
1950 он



Шууданч бүсгүй.  
1980 он

Монгол улс дэлхийн асар өргөн удам нутгийг эзлэн оршиж байсан үед 1228-1241 онд Монголын эзэнт гүрний хаан ширээнд сууж байсан Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөдэй мэдээлэгч, захирагч нарыг бий болгож морин өртөө байгуулсан нь шуудан харилцааны хувьд уургын улааг халж, мэдээлэл харилцаа дамжуулах сүлжээг үүсгэн байгуулсан томоохон дэвшил билээ.

Өртөө нь улам боловсронгуй болон хөгжсөөр Ардын хувьсгал мандсан 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн 100 жилийн түүхт Монгол Шуудан юм.

1921-07-19	1935	1935-1936	1936-1958	1958-1960
Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав.	Нийслэлийн Шуудангийн хороо	Нийслэлийн Төв Холбооны Төв шуудан тасаг	Холбооны Ерөнхий Хорооны харьяа Төв	Шуудан Цахилгаан Шуудангийн хороо



#### Хувьцаат компанид шилжсэн шийдвэр:

**1.** Монгол Улсын Их Хурлын 2015 он

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” 70 дугаар тогтоол

**2.** Монгол Улсын Засгийн газрын 2015 он

“2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 330 дугаар тогтоол

**3.** Төрийн өмчийн хорооны 2015 он

“Нэмэлт хувьцаа гаргах тухай” 594 дүгээр тогтоолуудаар “Монгол Шуудан” ХК болгон өөрчлөв.



1966-1978

Төв Шуудан

1978-1990

Цахилгаан  
Шуудан  
Холбооны  
газар

1990-1994

Шуудан  
Холбооны  
газар

1994

Монгол  
Шуудан  
ТӨУҮГ

2002

Монгол  
Шуудан  
ХХК

2009

Монгол  
Шуудан  
ТӨХК

2016

Монгол  
Шуудан  
ХК



Фото зургийг Боргодогйхүү  
Улаанбаатар хот



МОНГОЛ  
ШУУДАН

2022 ОНЫ  
ОНЦЛОХ АЖЛУУД

## 2022 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД



### ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН СИСТЕМ НЭВТРҮҮЛЭВ

Компанийн орлого, ажил үйлчилгээний чанарыг ажилтны ажлын гүйцэтгэлтэй уялдуулах үүднээс Цалин, урамшууллын журмыг шинэчлэн баталж, ажилтны ажлын бүтээмж, үр дүнд суурилсан цалин урамшууллын системийг мөрдөн ажиллаж байна.



### АЖИЛЧДЫН ДУНД ДӨРВӨН ТӨРӨЛТ СПОРТЫН ИХ НААДАМ 2022

ДӨРВӨН ТӨРӨЛТ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ Агар спорт төвд 2022 оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд 4 төрөлт спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулж Захиргаа, хүний нөөцийн газар баг хамт олноороо “Аварга”-ын цомын эзэн болсон. Улаанбаатар орон нутгийн нийт 498 тамирчид оролцсон байна.



### ХАМТЫН ГЭРЭЭ

“Монгол шуудан” ХК болон Бүгд Найрамдах Эстони Улсын шуудангийн байгууллага /Эсти шуудан/ хооронд “Онлайн худалдааны бараа бүтээгдэхүүний хүргэлт, тээвэрлэлтийг хамгийн хямд бөгөөд хурдан, шуурхай болгох чиглэлд хамтран ажиллах гэрээ” байгууллаа.



### АГААРЫН ТРАНЗИТ ШУУДАН ТЭЭВРИЙГ ЭХЛҮҮЛЭВ

Бүс нутгийн дамжин өнгөрөх транзит шуудангийн хэмжээг нэмэгдүүлэх, хурд, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тээврийн олон хувилбар, маршрутаар ачаа тээврийг тээвэрлэв. Үүнд агаарын тээвэр, төмөр зам, авто замын холимог тээврээр дамжин өнгөрөх шууданг тээвэрлэснээр хэрэглэгчдэд сонголт бий болгож, хэмжээг нэмэгдүүлэв. Түүнчлэн транзит шуудангийн шимтгэлийн хувь хэмжээг 50 хувь нэмэгдүүлснээр компанид ноогдох орлогын хэмжээг нэмэгдүүлэв.



### ЯПОН УЛСААС ОРОХ ШУУДАН СОЛИЛЦООГ ЭХЛҮҮЛЭВ

Япон улсаас орох шуудангийн үйлчилгээ 2 жилийн хугацаанд бүрэн зогссон байсан ба тухайн орнуудын шуудангийн байгууллагын удирдлагуудтай удаа дараа уулзалт зохион байгуулж, мөн тэдгээр улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамдаар дамжуулан албан хүсэлтүүдийг тавьснаар 2022 оны 5 сард Япон улсаас, 9 сард БНСУ-аас Монгол улс руу чиглэсэн шуудангийн үйлчилгээг эхлүүлж чадлаа.





### ICT 2022 СПОРТЫН ИХ ТЭМЦЭЭН 2022

2022 оны 05 дугаар сарын 23-30-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 40 тамирчин оролцон ШАТАР /эм/, 3\*3 /эр/, ВОЛЕЙБОЛ /эм/ 3 төрөлд мөнгөн медалийн эзэд болж тэмцээнд амжилттай оролцсон.



### САЛБАРЫН 101 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН 14 АЖИЛТНЫГ ТӨРИЙН БОЛОН САЛБАРЫН ДЭЭД ШАГНАЛААР ШАГНАВ

- Төрийн дээд одон медаль 3
- Хүндэт холбоочин 2
- Шуудангийн тэргүүний ажилтан 9



### СУРГАЛТ

Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд танхим болон цахим хэлбэрээр нийт 13 удаагийн сургалтаар 463 ажилтныг хамруулав.



### ТӨВ САЛБАРЫН НЭЭЛТ

2022 оны 12 сарын 02 ний өдөр “Монгол шуудан”ХК-н төв салбарын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Ард Санхүүгийн Нэгдлийн хамт олноос Монгол Улсад харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Төр-Хувийн хэвшлийн сайн жишгийг тогтоож, Улаанбаатар хотын төв цэг болох Төв Шуудан дахь салбарыг олон улсын стандартад нийцүүлэн засварлан тохижуулж, хүлээлгэн өглөө.



### “ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХӨГЖИЛ-2022” БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨН

Харилцаа холбооны зохицуулах хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Харилцаа холбооны хөгжил-2022” бүсийн зөвлөгөөн, өдөрлөг арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын 07-08-ний өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж “Монгол шуудан” ХК БТХГ газар болон ДШҮГ хамтран оролцсон.



## 2022 ОНЫ ОНЦЛОХ АМЖИЛТУУД



### ДАРХАН ШҮГ-ЫН БҮРЭН ЗАСВАРЛАЖ НЭЭЛТ ХИЙВ

Дархан-Уул аймагт төр-хувийн хэвшлийн сайн жишиг тогтоож Шуудан, Санхүүгийн үйлчилгээ болон Төрийн цахим үйлчилгээг үзүүлэх шинэ салбарын нээлтийг хийлээ. Тус жишгийн дагуу ирэх жилүүдэд орон нутгийн салбаруудаа тохижуулан засаж үйлчилгээний нэр төрлөө нэмэгдүүлж тус бүс нутагт ажиллаж, амьдарч буй иргэдэд санхүүгийн болон төрийн цахим үйлчилгээг ойртуулах болно.



### ШУУДАНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН ПОСТНЕТ СИСТЕМИЙГ 8 ЖИЛИЙН ДАРАА ШИНЭЧЛЭВ

2010 онд Шинэ тоног төхөөрөмж, технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдсон "PostNet v2" програмыг, 2014 онд Шуудан бүртгэл хяналтын "PostNet v3" системийн 3-р хувилбарыг, 2022 онд Шуудан бүртгэл, удирдлагын систем "ePostNet v4" системийн 4-р хувилбар хүртэл шинэчлэн хөгжүүлэлт хийн ашиглаж байна.



### ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛАВ

2022 онд хамт олноо манлайлан, үр бүтээлтэй ажилласан 14 ажилтныг шилдгээр шалгаруулан урамшуулав.



### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН 2022 ЧУУЛГАН

Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэх хамгийн том чуулган Хөрөнгө Оруулагч Үндэстэн – 2022 6 дахь удаагаа 4 сарын 30, 5 сарын 1-ний өдрүүдэд Corporate Convention Center-т зохион байгуулагдлаа. "Монгол шуудан" ХК үзэсгэлэнд оролцож өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан оролцлоо.






---

### НААДМЫН ТАСАЛБАР ЗАХИАЛГА, ХҮРГЭЛТ

Төрийн цахим үйлчилгээ өргөжиж, шуудангаар авах үйлчилгээний нэр төрөл нэмэгдсээр байна. Анх удаа наадмын тасалбар захиалгыг шуудангаар хүргэв.




---

### E-MONGOLIA


“Монгол шуудан” ХК нь Цахим хөгжил харилцаа холбооны яам болон Улсын бүртгэлийн Ерөнхий газартай хамтран төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia.mn-ээр захиалагдсан Иргэний үнэмлэх болон Жолооны үнэмлэхийг хүргэж гардууллаа.




---

### ОРИФЛЭЙМ, ОЮУТОЛГОЙ, АРДШОП ЗЭРЭГ В2С ЗАХИАЛГАТ ХҮРГЭЛТ


- Орифлэйм, Хэрбалайф компанийн Хотын доторх болон Орон нутгийн тогтмол хүгэлт Оюутолгой, Хаанбанк, Голомт банк зэрэг томоохон харилцагчдын захиалгат хүргэлт
- Ардшоп, Шоппи, Hibox зэрэг онлайн худалдааны захиалгат хүргэлт
- Баяр ёслолын үеийн захиалгат хүргэлт




# ХҮНИЙ НӨӨЦ



2022 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд 6 газар, 3 хэлтэс, 5 төв, 7 дүүргийн шуудангийн үйлчилгээний газар, 1 автобааз, 2 шуудангийн үйлчилгээний салбар, 21 аймгийн шуудангийн үйлчилгээний газрын 327 сумдад нийт 1009 ажилтан ажиллаж байна.



Ажиллах хүч нь Улаанбаатар хотод **440**, Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт **519** ажилтан, Хүүхэд асрах чөлөөтэй ажлын байрыг хэвээр хадгалж үлдээх 44 ажилтан, Жирэмсний амралттай **6** ажилтан байна.



Хүйсийн хувьд авч үзвэл **71,4%** хувь нь эмэгтэй, **28,6%** хувь нь эрэгтэй ажилтан байна. Энэ нь 2021 онтой харьцуулбал нийт ажилтанд ногдох эрэгтэй ажилтны хувийн жин 1,2%-иар буурсан байна.


НИЙТ  
КОМПАНИЙН  
ХЭМЖЭЭНД  
**1009**  
АЖИЛТАН  
БАЙНА

2022 оны IV-р улирлын байдлаар компанийн хэмжээнд

**6** газар, **3** хэлтэс, **5** төв, **7** дүүргийн шуудангийн үйлчилгээний газар, **1** автобааз, **2** салбар, **21** аймгийн **327** сумдад нийт **1009** ажилтан ажиллаж байна.

### Нийт ажилтны тоо


● Нийт ажилтны тоо




### Хэрэглэгчийн үйлчилгээний чанар

2022 оны байдлаар хэрэглэгчид Монгол шуудангаар үйлчлүүлэхдээ хэр сэтгэл ханамжтай байгааг тодорхойлох зорилгоор анкетын аргаар 350 үйлчлүүлэгчдийн дунд судалгааг түүвэрлэн явууллаа.

### Судалгааны хэмжүүр үзүүлэлт



### Судалгаанд оролцогчдын нас болон хүйсийн ангилал



# ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ

Нийт **114.365** дуудлага ирснээс **101.757** (89%) дуудлагыг амжилттай авч хариулсан бол **3370** (2.9%) дуудлага алдаж, хэрэглэгч өөрөө **5124** (4.5%) дуудлагыг хүлээн авахаас өмнө тасалж, **4114** (3.6%) дуудлагыг өөр хэсэгт шилжүүлэн хариу өгсөн байна. Нэг дуудлагын дундаж хугацаа нь **1 мин 06 секунд**ийн хугацаатай байв.



ХҮТ-1613-т **105.527** дуудлага ирсэн.

92.3%

Газар хэлтэст **1154** дуудлага ирсэн.

■ 1.0%

УБ-ын ШҮС-т **4629** дуудлага ирсэн.

■ 4.0%

Аймаг орон нутгийн ШҮГ-т **3055** дуудлага ирсэн.

■ 2,7%

Фэйсбүүк чат, коммент

www.Mongolpost.mn веб сайт

Утсаар

Имэйл /customer@mongolpost.mn/

Дуут шуудан /колл про/

Инстаграм

ДШХ-ийн тест дуудлага

УХШ хяналт /лавлагаа илгээсэн, хариулсан/

Эргэж холбогдсон дуудлага

16198

102 улс, 1,245 хотын 31.515

114.365

1338.

63

45

84

882

4114

ЛАВЛАХ ТӨВИЙН ОПЕРАТОРУУД ОЛОН УЛСЫН ШУУДАНГИЙН СИСТЕМ **GCSS, IPS, I-CARE, POST NET-ДОТООД СИСТЕМ, E-MONGOLIA, MYDELIVERY. MN, MONGOLPOST.MN** ЧАТ, **FACEBOOK, TWITTER** ЧАТ ГЭХ МЭТ ОЛОН СУВАГ САЙТ ДЭЭР АЖИЛЛАЖ ХЭРЭГЛЭГЧДЭДЭЭ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ӨГЧ БАЙНА.





Улс хоорондын гарах шуудан илгээмжийг сааталгүй хүргэхэд анхаарч байршлын мэдээлэлд тогтмол хяналт хийж улс хоорондын

**гарах шууданд 25148, орох шууданд 2901**

лавлагааны хариу өгсөн.

Нийтдээ лавлах GCSS, I-Care системээр **8458** лавлагаа илгээсэн байна

Дэлхийн шуудан холбооны чанарын тест дуудлага, тест мэйлд цаг алдалгүй **364** хариу өгсөн

2022 онд Турк болон БНСУ улсаар гарсан нийт **18007** шуудан хянасан байна.  

- Буухиа илгээмж **7028**
- Илгээлт **3978**
- Бичиг захидал , боодол **7001**

Нийт илгээмжийн **94,3%** нь буюу **16,310** шуудан гардуулагдсан байна.

- Хүргэгдэхээр хүлээгдэж буй **1389**
- Алга болсон **31**
- Гаалиас аваагүй буцсан **92**
- Гааль дээр саатсан **34**
- Хаяг алдаатай буцсан шуудан **43**
- Шуудангаа аваагүй тул буцаасан шуудан **113**
- Нийт гардуулагдаагүй байгаа **1702** шуудан байна.

12 дугаар сард гарсан зарим шуудан хяналтын хугацаандаа явж байгаа тул үргэлжлүүлэн хяналт хийн ажиллаж байна.

# ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ ТАЛААР



**Улс хоорондын шуудангийн үйлчилгээ, солилцооны талаар**


Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2 жилийн хугацаанд орох шуудангийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байсан бөгөөд үйл ажиллагааг сэргээх тал дээр анхаарч ажилласан бөгөөд үүн дотроо шуудангийн солилцоо ихтэй улсууд болох Япон, БНСУ-ын шуудангуудтай албан уулзалтуудыг зохион байгуулснаар үйл ажиллагааг хэвийн болгоод байна. Тайлант хугацаанд **173.5тонн, 126083ш** орох шуудан хүлээн авч ялган боловсруулсан байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд **144.2%**-иар, тоо ширхэг нь **41.2%**-иар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

**Чанарын тайлан мэдээлэл, чанар сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд**

Тайлант хугацаанд орох нийт илгээмжийн гардуулалтын дундаж **94.9%** байна. Нийт орох бичиг захидал, боодлын **90.4%**-ийг, буухиа шуудангийн **97.9%** илгээлтийн **96.3%**-ийг тус тус хяналтын хугацаанд нь хүргэж гардуулсан байна.

**Гардуулалт** | хувиар, улирлаар

■ LC/AO  
■ EMC  
□ Parcel



## ТЭЭВРИЙН МАРШРУТЫГ ОНОВЧЛОХ

УХШ-ийн орлого, солилцоог нэмэгдүүлэхийн тулд **Ази, Европ** болон бусад улсуудад шуудан гаргах маршрутыг тогтоон, **88 улс** руу шуудан явуулах боломжтой болсон.

**Азийн** орнуудыг **Япон** улсын шуудангийн байгууллагаар, **Европ, Африк** болон бусад улсууд руу Туркийн шуудангийн байгууллагаар нээлттэй дамжуулан **60-аад** улсад, зөвхөн агаарын тээврийн байгууллагаар дамжуулан **24 улсад** битүүмжилсэн богц хэлбэрээр шуудан илгээж байна.

### Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

QSF-ийн санхүүжилтээр “Шинэ нисэх буудал болон ЯБТ-ийн хоорондох шуудан таталтыг сайжруулах” төслийн хүрээнд **2.5-3 тонны даацтай ачааны тээврийн** хэрэгслийг худалдан авах төслийг боловсруулан хэрэгжүүлэх саналаа ДШХ-ны Үйлчилгээний чанарын санд хүргүүлээд байна.

### Хамтын ажиллагааны хүрээнд:

**МИАТ, Туркиш Эйрлайнс, АНА** тээврийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээ шинэчлэж хийн, **Аэрофлотын** тээврийн гэрээг **Артис Ложистик** компаниар дамжуулан мөн Солонгос улсын “**СJ Логистик**” компанитай шуудан тээвэрлүүлэх гэрээг шинээр хийгээд байна.



# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

2022 онд Цахим шилжилт, систем шинэчлэлийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд ашиглагддаг үндсэн **3** системийг бүрэн шинэчилсэн.

## 1. Дотоод шуудан бүртгэлийн систем

Шуудан бүртгэлийн систем шинэчлэл, шууданчийн гардуулалтын аппликейшн шинэчлэл, маршрут тээврийн хуваарийн бүртгэл, жолоочийн аппликейшн зэрэг хөгжүүлэлтүүд хийгдсэн.



## 2. International Postal System 2021 upgrade



IPS2017 хувилбараас IPS2021 хувилбарт амжилттай шилжсэн.

## 3. Цалин, Цаг бүртгэл, Хүний нөөцийн систем



Цалин, цаг бүртгэл, хүний нөөцийн **Green ERP** систем нэвтрүүлсэн.

Мөн шинээр **CDS** (Customs Declaration System) систем хөгжүүлсэн.






Улс хоорондын гаалийн системд нэгдсэн ба Илгээмжийн мэдээллийг цахимаар урьдчилан солилцдог болсон.

Ингэснээр үндсэн үйл ажиллагаандаа **4** систем ашигладаг болсон.



# ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

## ХОТ ДОТОРХ ХҮРГЭЛТ - ГАРААС ГАРТ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

-  Уламжлалт явган хүргэлтээс, үе шаттайгаар автомашинтай хүргэлт рүү шилжих
-  Автомашины тоог нэмэгдүүлж, Улаанбаатар хотын болон Орон нутгийн хүчин чадлаа нэмэгдүүлэв
-  Бүртгэлийн систем, Вэбсайтын шинэчлэлээр онлайн захиалга, хүргэлтийг шинэ шатанд гаргана



### eMongolia: Захиалга, хүргэлт

Төрийн цахим үйлчилгээ өргөжиж, шуудангаар авах үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж байна



Анх удаа Үндэсний их баяр наадмын тасалбар захиалгыг шуудангаар хүргэв

E-Mongolia – аар захиалсан иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг хүргэв

### B2C захиалгат хүргэлт

Орифлэйм, Хэрбалайф компанийн Хотын доторх болон орон нутгийн тогтмол хүргэлт

Оюутолгой, Хаанбанк, Голомт банк зэрэг томоохон харилцагчдын захиалгат хүргэлт

Ардшоп, HiBox зэрэг онлайн худалдааны захиалгат хүргэлт

Баяр ёслолын үеийн захиалгат хүргэлт



# УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ



## ГАДААД ШУУДАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР | Гаргах шуудан

### Шуудан экспортын хэмжээ | ширхэг



3.8% ↑



### Шуудан экспортын хэмжээ | жин



43% ↓



Экспортын шууданг БНТУ, БНСУ-аар дамжуулан экспортын тээврийг зохион байгууллаа

## ГАДААД ШУУДАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР | Орох шуудан

### Шуудан импортын хэмжээ | ширхэг



41% ↑



### Шуудан импортын хэмжээ | жин



144% ↑



Гол зах зээл болох БНСУ, Япон улсаас орох шуудангийн урсгалыг нээж, жигдрүүлэв.

## АНУ болон Европын холбооноос онлайн худалдаа хийх ХЯМД, бас ХУРДАН болно



Монгол шуудан ХК болон Бүгд Найрамдах Эстони Улсын шуудангийн байгууллага /Эсти шуудан/ хооронд “Онлайн худалдааны бараа бүтээгдэхүүний хүргэлт, тээвэрлэлтийг хамгийн хямд бөгөөд хурдан, шуурхай болгох чиглэлд хамтран ажиллах гэрээ” байгууллаа.

Энэхүү гэрээ байгуулагдсанаар АНУ болон Европын холбооны улсуудаас Монгол улсын хооронд онлайн худалдаа эрхлэгчид, АНУ-ын Амазон(Amazon), Ибэй(Ebay)... гэх мэт томоохон сайтын хэрэглэгчид хамгийн хурдан, хамгийн хямд зардлаар, хамгийн найдвартай байдлаар бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах боломж бүрдэх юм.



*\* Дээрх төсөл хэрэгжсэнээр шуудангийн салбарт ацих, дэвшил гарна*

Уг төслийн хүрээнд Монгол шуудан ХК-нь Хөшигтийн хөндийн Олон Улсын нисэх буудалд байрлах Ялган боловсруулах төвөөр дамжуулан АНУ болон Европын холбооны улсуудаас ирэх онлайн худалдааны бараа бүтээгдэхүүний тээвэр, логистик, гаалийн бүрдүүлэлт, гаалийн хадгалалт, дотоодын тээвэр, хаягийн хүргэлт гэх мэт иж бүрэн үйлчилгээг санал болгох ба ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн шуудан илгээмж, каргоны компаниуд, онлайн худалдаа эрхлэгч байгууллагуудтай агаарын тээврийн илүү хямд, хурдан тээвэрлэх шинэ гарц нээж хамтран ажиллах боломжийг бүрдүүлж байгаа юм.

# ДОТООД ШУУДАН ●



Энэ онд 196388 ширхэг богцоор, 1284,6 тн жинтэй, нийтдээ **2,115,409** ширхэг шуудангийн илгээмжийг хүлээн авч, ялган боловсруулж, хүргэсэн байна. Орон нутагт шуудан хүргэх тээврийн хуваарийг сар бүр гарган батлуулж, хуваарийг мөрдүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд 7 хоногт 21 аймагт 6 удаа, 42 суманд 3 удаа, 132 суманд 2 удаа, 153 суманд 1 удаа, Нийслэл хотын 40 гаруй салбарт өдөрт 2 удаа тогтмол шуудан хүргэж байна.

| ширхэг

БУУХИА ШУУДАН	<b>56,033</b>
БИЧИГ ЗАХИДАЛ	<b>1,848,195</b>
БООДОЛ	<b>130,091</b>
ИЛГЭЭЛТ	<b>79,690</b>
ХЭВЛЭЛ	<b>2,912,242</b>




Хүлээн авч, ялган боловсруулж, хүргэсэн нь илгээмжийн солилцоо түүхэндээ анх удаа **2,115,409** ширхэгт хүрсэн байна. Хэвлэлийн солилцоо **2,912,242** ширхгийг тус тус ялган боловсруулж, хүргэжээ.





Солилцоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад илгээмжийн солилцоо **2,8%**-иар өссөн, хэвлэл солилцоо 45,6%-иар буурсан, илгээмжийн хүндийн жин **62,2%**-иар өссөн үзүүлэлттэй байна.

## Солилцоо

■ 2021  
□ 2022



## Нийт солилцоо

	2018	2019	2020	2021	2022
Нийт солилцоо	2,397,599	2,653,661	2,399,497	2,410,063	<b>2,469,042</b>
 Дотоод	1,685,703	2,082,944	2,108,296	2,183,348	<b>2,182,005</b>
Бичиг захидал	1,512,814	2,009,719	2,002,527	1,867,891	<b>2,019,670</b>
Боодол	55,928	51,766	60,102	168,646	<b>101,059</b>
 Улс хооронд	21,961	21,459	45,667	146,811	<b>61,276</b>
Улс хооронд гарах	711,896	570,717	291,201	226,715	<b>287,037</b>
Улс хооронд орох	177,930	191,276	60,491	54,223	<b>60,429</b>

# УЛС ХООРОНДОХ ТРАНЗИТ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




## ТРАНЗИТ ШУУДАН

Хэмжээ | сая, ширхэг

2021  11 сая ш

2022  17 сая ш



146  
ТИР ТЭЭВЭР



34  
Нислэг



## ХОТ ХООРОНДЫН ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Улаанбаатараас 21 аймаг, алслагдсан 3 дүүрэг, томоохон сумуудын шуудан, ачааг 7 хоногт 1-5 удаагийн давтамжтайгаар 800 удаагийн тээврийг зохион байгуулав

Хот хоорондын тээврээр Улаанбаатар хотоос **161.9 мянган** богц, **1,027.8 тн** үндсэн шуудан, **107.7 мянган** ширхэг логистикийн ачаа, орон нутгаас мах, ачаа, шууданг тээвэрлэсэн.


2021 оны 3-р улирлаас жижиглэн ачаануудыг Postnet програмд бүртгэн, богцолж явуулдаг болсноор ачаа бараа алга болох, гэмтэх, бүртгэлгүй илгээмж явуулах зэрэг зөрчлүүдийг бууруулсан.

# САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АЖЛЫН ХҮРЭЭНД

## МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

“Монгол шуудан” ХК нь Ард Кредит ББСБ-тэй хамтран Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ Еврожайро системд нэгдсэнээр 2022 онд нийт **1987** удаагийн давтамжтайгаар **4,893,886,325.57₮**-н гүйлгээг амжилттай хийгээд байна. Бид цаашдаа мөнгөн гуйвуулгын үйлчилгээг илүү өргөжүүлэх хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон орон нутгийн шуудан үйлчилгээний салбаруудаар үзүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

	2020 он	2021 он	2022 он
Давтамж	75	842	1987
Дүн	<b>113,406,255.15</b>	<b>2,168,312,074.84</b>	<b>4,893,886,325.57</b>
Улсууд	13	54	31





# МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ХЭЛТЭС

МАРК ҮЙЛДВЭРЛЭЛ:


2022 онд 21 сэдвийн маркийг шуудангийн гүйлгээнд гаргаж, сурталчлах, түгээх, борлуулах ажлыг Шуудангийн үйлчилгээний салбаруудтай хамтран амжилттай зохион байгуулсан.



Бар жил



Монгол Улсын үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой



Галдан бошигт хаан





Дэлхийн жүжигчин Гомбожавын Гомбосүрэн




Монгол Улс-Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил



Монголын үлэг гүрвэлийн сор олдворууд






Тагнуулын байгууллагын 100 жил



Бакула Ринбүүчи



Төрийн хяналт-Аудитын байгууллагын 100 жил





Уран сийлбэр



Монгол хүүхэлдэйн кино






Чингис хааны  
мэндэлсний  
860 жил



Тэмээн сүрэг



Зээгт наамал






Монгол Улс-Австралын Холбооны Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой



Улаан номын амьтан, ургамал





Цагаан өвгөн



Бар жил



Чингис хаан



Гэрийн тооно



Дөрвөн хүчтэн



12 жил



Хээ



Үхэр жил



Хүннү дээл




Эвтэй дөрвөн амьтан

САНХҮҮГИЙН  
АЖЛЫН  
ХҮРЭЭНД

# ШУУДАНГИЙН НИЙТ СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018-2022 он | ширхэг



ОРЛОГО, ЦЭВЭР АШИГ | 2018-2022 он, сая.төгрөг


Дансны нэр	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>15,474.0</b>	<b>16,725.0</b>	<b>18,231.9</b>	<b>20,932.8</b>	<b>20,391.5</b>
Татварын дараах цэвэр ашиг	1,560.3	1,103.6	557.9	400.0	451.3



**НИЙТ ХӨРӨНГӨ** | 2018-2022 он сая.төгрөг

Тайлангийн үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Төгрөг	Өөрчлөлт
<b>Нийт хөрөнгө</b>	<b>34,010.9</b>	<b>33,484.5</b>	<b>37,366.3</b>	<b>32,095.0</b>	<b>43,511.4</b>	<b>11,416.4</b>	<b>35.6%</b>
Эргэлтийн хөрөнгө	25,637.3	24,463.4	27,606.0	22,346.3	32,998.0	10,651.7	47.7%
Эргэлтийн бус хөрөнгө	8,373.6	9,021.1	9,760.2	9,748.7	10,513.4	764.7	7.8%

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>75.4%</b>	<b>73.1%</b>	<b>73.9%</b>	<b>69.6%</b>	<b>75.8%</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>24.6%</b>	<b>26.9%</b>	<b>26.1%</b>	<b>30.4%</b>	<b>24.2%</b>








**НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | 2018-2022 он сая.төгрөг

Тайлангийн үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Төгрөг	Өөрчлөлт
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>34,010.9</b>	<b>33,484.5</b>	<b>37,366.3</b>	<b>32,095.0</b>	<b>43,511.4</b>	<b>11,416.4</b>	<b>35.6%</b>
<b>Өр төлбөр</b>	11,498.4	10,560.9	13,389.8	7,309.4	18,519.8	11,210.4	153.4%
<b>Эздийн өмч</b>	22,512.5	22,923.6	23,976.5	24,785.6	24,991.6	206.0	0.8%

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Өр төлбөр</b>	33.8%	31.5%	35.8%	22.8%	42.6%
<b>Эздийн өмч</b>	66.2%	68.5%	64.2%	77.2%	57.4%





- Эздийн өмч
- Өр төлбөр
- Нийт өр төлбөр ба эздийн өмч

**МӨНГӨН ХӨРӨНГӨ БА БУСАД ХӨРӨНГӨ** | 2018-2022 он сая.төгрөг

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Төгрөг	Өөрчлөлт
<b>Нийт хөрөнгө</b>	<b>34,010.9</b>	<b>33,484.5</b>	<b>37,366.3</b>	<b>32,095.0</b>	<b>43,511.4</b>	<b>11,416.4</b>	<b>35.6%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	17,267.1	16,648.9	21,059.0	14,304.0	19,386.0	5,082.0	35.5%
<b>Бусад хөрөнгө</b>	16,743.8	16,835.6	16,307.3	17,791.0	24,125.4	6,334.4	35.6%


	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Мөнгөн хөрөнгө</b>	50.8%	49.7%	56.4%	44.6%	44.6%
<b>Бусад хөрөнгө</b>	49.2%	50.3%	43.6%	55.4%	55.4%

**САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ** | 2021-2022 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он	2022 он
<b>Цэвэр ашиг</b>	төгрөг	400,046,154.68	451,283,091.44
<b>Нийт хувьцааны тоо</b>	ширхэг	99,586,363	99,586,363
<b>Нэгж хувьцааны үнэ</b>	төгрөг	1,350.00	994.84
<b>Нэгж хувьцааны дансны үнэ</b>	төгрөг	248.9	251.0
<b>Зах зээлийн үнэлгээ</b>	тэрбум төгрөг	134.4	99.1
<b>Нэгж хувьцааны өгөөж /EPS/</b>	төгрөг	4.02	4.53
<b>Нийт хөрөнгийн өгөөж /ROA/</b>	-	0.0125	0.0104
<b>Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROA/</b>	-	0.0161	0.0181
<b>Нийт хөрөнгийн эргэц /ROTA/</b>	-	0.0147	0.0140
<b>Бусад хөрөнгө</b>		16,743.8	16,835.6



## ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ АРИЛЖАА | 2022 он

### Хувьцааны үнийн өөрчлөлт



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ | 2021-2022 он

	2021 он	2022 он
Төрийн өмч	66%	66%
Ард Санхүүгийн Нэгдэл	23.60%	20.09%
Бусад	10.40%	13.91%



АУДИТ ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН  
БАЙДЛЫН  
ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

Төгрөг

Үзүүлэлт

2022.01.01

2022.12.31

1	ХӨРӨНГӨ		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,304,012,274.34	19,385,981,879.08
1.1.2	Дансны авлага	1,561,147,844.30	5,886,568,927.89
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	7,959,558.98	41,101,472.25
1.1.4	Бусад авлага	208,294,306.99	332,984,445.92
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	7,769,001.00	157,769,001.00
1.1.6	Бараа материал	2,778,743,420.48	3,479,935,861.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,478,342,480.47	3,713,694,026.89
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>22,346,268,886.56</b>	<b>32,998,035,614.88</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	0.00	0.00
<b>1.2.1</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	8,522,799,977.58	8,471,048,949.22
1.2.2	Биет бус хөрөнгө	1,225,448,481.99	2,041,828,165.60
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>9,748,748,459.57</b>	<b>10,513,377,114.82</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,095,017,346.13</b>	<b>43,511,412,729.70</b>

>>

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт

2021.12.31

2022.12.31

<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,062,957,616.02	17,778,450,709.99
2.1.1.2	Цалингийн өглөг	35,000.51	-
2.1.1.3	Татварын өр	238,806,355.76	168,138,133.12
2.1.1.4	НДШ-ийн өглөг	759,786.83	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	463,892,631.47	339,069,766.99
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	548,527,942.84	234,143,968.36
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,314,979,333.43</b>	<b>18,519,802,578.46</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.2</b>	<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>7,314,979,333.43</b>	<b>18,519,802,578.46</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2	- хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,300,458,597.23	4,300,458,597.23
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,602,511,381.17	4,814,083,519.71
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>24,780,038,012.70</b>	<b>24,991,610,151.24</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>32,095,017,346.13</b>	<b>43,511,412,729.70</b>

## АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2022-12-31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

Төгрөг

Үзүүлэлт

2021.12.31

2022.12.31

1	<b>Борлуулалтын орлого (Цэвэр)</b>	<b>19,838,796,351.51</b>	<b>18,491,088,870.70</b>
2	Борлуулалтын өртөг	19,328,556,601.34	18,464,332,021.74
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>510,239,750.17</b>	<b>26,756,848.96</b>
4	Түрээсийн орлого	103,289,121.67	115,241,194.05
5	Хүүний орлого	406,304,998.11	584,082,910.22
6	Ногдол ашгийн орлого	0	0
7	Эрхийн шимтгэлийн орлого	0	0
8	Бусад орлого	0	0
9	Борлуулалт маркетингийн зардал	0	0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	917,446,523.39	1,147,771,767.30
11	Санхүүгийн зардал	0	0
12	Бусад зардал	215,189,538.24	170,052,835.67
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	566,539,914.40	1,201,078,732.14
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	17,882,888.57	0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	0
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0	0
17	Бусад ашиг (алдагдал)	0	0
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>471,620,611.29</b>	<b>609,335,082.40</b>
19	Орлогын татварын зардал	71,574,456.61	158,051,990.96
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>400,046,154.68</b>	<b>451,283,091.44</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0	0
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>400,046,154.68</b>	<b>451,283,091.44</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0	0
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
26	Бусад олз гарз	0	0
27	Орлогын нийт дүн	0	0
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	400,046,154.68	451,283,091.44

# АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Төгрөг

Үзүүлэлт

2021.12.31

2022.12.31

1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>102,131,088,744.62</b>	<b>125,901,989,790.76</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	20,116,138,649.08	14,849,382,704.84
1.1.2	Эрхийн шимтгэл, хүлээн авсан мөнгө	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	13,686,589.77	0
1.1.4	Буцаан авсан албан татвар	415,286.40	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	3,577,925,614.00	0
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	78,422,922,605.37	111,052,607,085.92
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>105,997,364,812.61</b>	<b>121,450,100,365.99</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	7,576,084,212.43	7,244,776,405.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,269,634,977.60	2,266,214,006.36
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,576,691,055.82	2,949,629,551.54
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,435,630,830.97	1,819,030,861.01
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,640,000,864.29	3,240,415,086.86
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,418,040,429.93	1,334,722,721.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	95,730,064.77	116,694,757.20
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	87,985,552,376.80	102,478,616,976.39
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-3,866,276,067.99</b>	<b>4,451,889,424.77</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0</b>	<b>0</b>
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>347,838,409.42</b>	<b>357,082,910.22</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0	0

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	347,838,409.42	357,082,910.22
2.1.7 Хүлээн авсан ногдол ашиг	0	0
2.1.8 ХО бусад мөнгөн орлого	0	0
<b>2.2 Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,552,769,138.00</b>	<b>1,777,149,476.43</b>
2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,388,365,712.00	1,343,924,826.43
2.2.2 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	164,403,426.00	283,224,650.00
2.2.3 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	150,000,000.00
2.2.4 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.5 Буцаан олгосон зээл болон урьдчилгаа	0	0
2.2.6 ХО бусад мөнгөн зарлага	0	0
<b>2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-2,204,930,728.58</b>	<b>-1,420,066,566.21</b>
<b>3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>3.1 Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>0</b>	<b>0</b>
3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.3 Төрөл бүрийн хандив	0	0
3.1.4 СҮА-ны бусад мөнгөн орлого	0	0
<b>3.2 Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>161,552,422.37</b>	<b>192,939,819.90</b>
3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0	0
3.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
3.2.3 Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0	0
3.2.4 Төлсөн ногдол ашиг	161,552,422.37	192,939,819.90
3.2.5 СҮА-ны бусад мөнгөн зарлага	0	0
<b>3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-161,552,422.37</b>	<b>-192,939,819.90</b>
<b>4 валютын ханшийн зөрүү</b>	<b>-522,204,291.98</b>	<b>2,243,086,566.08</b>
4.1 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-6,754,963,510.92	5,081,969,604.74
<b>5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>21,058,975,785.26</b>	<b>14,304,012,274.34</b>
<b>6 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14,304,012,274.34</b>	<b>19,385,981,879.08</b>




## АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Төгрөг Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,673,789,311.73	4,425,622,560.75	<b>23,976,479,906.78</b>
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	-	400,046,154.68	<b>400,046,154.68</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	626,669,285.50	(55,789,334.26)	<b>570,879,951.24</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(167,368,000.00)	<b>(167,368,000.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
<b>2021 оны 12-р сарын __-ээрх үлдэгдэл</b>	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,602,511,381.17	<b>24,780,038,012.70</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,602,511,381.17	<b>24,780,038,012.70</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	451,283,091.44	<b>451,283,091.44</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	(40,000,042.00)	<b>(40,000,042.00)</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(199,710,910.90)	<b>(199,710,910.90)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,814,083,519.71	<b>24,991,610,151.24</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(199,710,910.90)	<b>(199,710,910.90)</b>
<b>2022 оны 12-р сарын __-ээрх үлдэгдэл</b>	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	4,300,458,597.23	4,814,083,519.71	<b>24,991,610,151.24</b>



ГАДААД ШУУДА  
INTERNATIONAL M

 TheMongolPost  
 Монгол шуудан /Mongol shuudan/  
 [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)

## “МОНГОЛ ШУУДАН” ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106,  
Улаанбаатар-15160, Монгол улс

+(976) 1800-1613

[info@mongolpost.mn](mailto:info@mongolpost.mn)

